



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 1/141

Мандалговь

“Дундговь авто зам” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжих “Авто замын асфальт нийлүүлэх” ажлыг 61,200,000 (жаран нэгэн сая хоёр зуун мянга) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Дундговь авто зам” ХХК-тай 61,200,000 (жаран нэгэн сая хоёр зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан техникийн үзүүлэлт, хэмжээний “Авто замын асфальт нийлүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Дундговь авто зам” ХХК-ийн захирал (Х.Баяртогтох)-т үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Д. ДОРЖБАТ



150402